

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН 2024 ОНЫ 01 ДҮГЭЭР
АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

7.1. Хяналт, үнэлгээний тогтолцоог олон улсын жишиг хүргэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон дунд, богино хугацааны бусад бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг уялдуулан үнэлэх чиглэлээр олон улсын үнэлгээний цогц систем (DME – Design, Monitoring and Evaluation)-ийг нэвтрүүлэх;

Биелэлт: Хяналт шалгалтын тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний цогц систем (DME - Design, Monitoring and Evaluation)-ийг хөгжүүлж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үнэлгээг боловсронгуй болгох зорилгоор хяналт, үнэлгээний цогц систем (DME)-ийг нэвтрүүлэх асуудлыг судлан, санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.

Ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг баталж, энэ хүрээнд ажлын хэсгээс олон улсын үнэлгээний цогц систем нэвтрүүлэх асуудлыг дотоод нөхцөл байдал болон олон улсын байгууллага, гадаад улс орнуудын түвшинд судалж, тэдгээрийн сайн туршлага дээр үндэслэн Монгол Улсын нөхцөл байдалд хэрэгжүүлэх боломжит хувилбаруудыг тодорхойлж, санал боловсруулахаар ажиллаж байна.

“Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын тогтолцоо”-г амжилттай хөгжүүлсэн Малайз улсын туршлагаас харахад, тус удирдлагын тогтолцоог амжилттай хөгжүүлэхэд Үнэлгээний цогц систем (DME)-ийг хөгжүүлж, бодит амьдралд нэвтрүүлсэн нь гол түлхэц болсон бөгөөд энэхүү тогтолцооны загвар болон Монгол Улсын хөгжлийн бодлогын төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулсан хууль, журмын хүрээнд хяналт, үнэлгээний цогц системийн эхний загварыг гаргасан.

7.2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, холбогдох бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтийг улирал бүрээр тайлагнах, жил бүрийн эцэст үнэлж танилцуулах;

Биелэлт: Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21.1 дэх хэсэг, Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д тус тус зааснаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол

Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Улмаар хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдаанаас гарсан 41 дүгээр тэмдэглэлийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын нэгдүгээр үе шат буюу 2021-2030 онд “Үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Хүний хөгжил”, “Амьдралын чанар ба дундаж давхарга”, “Эдийн засаг”, “Засаглал”, “Ногоон хөгжил”, “Амар тайван аюулгүй нийгэм”, “Бүс, орон нутгийн хөгжил”, “Улаанбаатар ба дагуул хот” гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт, 965 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаснаас яамд, байгууллагуудаас ирүүлсэн 947 үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц 2024 оны 10 дугаар сарын байдлаар дунджаар 58.7 хувь байна. Нийт үйл ажиллагааны 27 үйл ажиллагаа буюу 2.9 хувь нь “үр дүнтэй”, 475 үйл ажиллагаа буюу 17.7 хувь нь “тодорхой үр дүнд хүрсэн”, 381 үйл ажиллагаа буюу 57.9 хувь “эрчимжүүлэх шаардлагатай”, 64 үйл ажиллагаа буюу 21.5 хувь “үр дүнгүй” үнэлэгдсэн байна.

Хэрэгжилтийн байдлыг үндсэн 9 зорилгын хүрээнд авч үзэхэд:

1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл	70.9%
2. Хүний хөгжил	56.8%
3. Амьдралын чанар ба дундаж давхарга	62.1%
4. Эдийн засаг	55.8%
5. Засаглал	68.0%
6. Ногоон хөгжил	55.0%
7. Амар тайван аюулгүй байдал	61.9%
8. Бүс орон нутгийн хөгжил	54.4%
9. Улаанбаатар ба дагуул хот	52.0%

Улсы Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г баталсан. Нийт 9 зорилгын хүрээнд 73 шалгуур үзүүлэлтийг баталсан бөгөөд хүрэх түвшнийг 2025 он, 2030 он, 2050 оноор тус тус тодорхойлсон. 2024 оны 10 дугаар сарын байдлаар 73 шалгуур үзүүлэлтээс 13 шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлсэн бөгөөд 60 шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлээгүй буюу тайлан гарах хугацаа болоогүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний 73 шалгуур үзүүлэлтээс 2025 оны зорилтод түвшинг хангасан 8 шалгуур үзүүлэлт байгаа ба бусад шалгуур үзүүлэлтүүд суурь оны түвшнээс сайжирч, зорилтот оны түвшин рүү дөхсөн эерэг төлөвтэй байна.

Цаашид “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүрээр гаргаж, хэрэгжилтийн явцыг үнэлэх тайлант хугацааны шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг оновчтой тодорхойлох шаардлагатай төдийгүй шалгуур үзүүлэлт, статистик мэдээлэл гарах хугацаа, тайлагналтын хугацаа, үнэлгээ хийх цаглаварыг уялдуулан боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

Хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг хангах үйл ажиллагааг дунд, богино хугацааны бодлогын зорилго, зорилтын хүрэх үр дүнтэй уялдуулж, нэгдмэл цогц, харилцан уялдаатай байх зарчмыг бүрэн хангах, хөгжлийн бодлогын төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээг нэгдмэл тогтолцоотой, харилцан уялдаатай хэрэгжүүлэх талаар эрх зүйн орчин бий болгох, удирдлагын нэгдсэн цахим системийг бий болгох зайлшгүй шаардлагатай байгааг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанд танилцуулан 41 дүгээр тэмдэглэлийн дагуу дээрх асуудлаар санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулахаар төлөвлөлт хийн ажиллаж байна.

7.3. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүдийг салбар бүрээр ангилан боловсруулж, Засгийн газрын гишүүдийн ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулан тооцох;

Биелэлт: Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын 7.3-т заасны дагуу нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүдийг салбар бүрээр ангилан боловсруулж, Засгийн газрын гишүүдийн ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулан тооцох үүргийн хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд яамдаас санал авах зорилгоор зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан.

Уулзалтад 16 яамны холбогдох нэгжийн албан тушаалтан, албан хаагчид оролцож ажлын хэсгээс боловсруулсан үзүүлэлт, тооцох аргачлалтай танилцаж санал солилцсон. Зөвлөлдөх уулзалтаар гарсан саналыг албажуулах зорилгоор нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг салбар бүрээр ангилан яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 01/1037 дугаартай санал ирүүлэх тухай хугацаатай албан бичиг хүргүүлж ажилласан. Саналын үндэслэл, тооцооллыг харгалзан үзэж нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг эцэслэн боловсруулж, тогтоолын төсөлд санал авч нэгтгэх ажил хийгдэж байна.

7.4. Салбарын хяналт шалгалт давхардаж байгаагаас шалтгаалж аж ахуйн нэгжүүдэд учирч буй хүндрэл, чирэгдлийг арилгах, давхардлыг бууруулах ажлыг удирдан зохион байгуулах;

Биелэлт: Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын 2024 оны А/23 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд салбарын хяналт шалгалт давхардаж байгаагаас шалтгаалж аж ахуйн нэгжүүдэд учирч буй хүндрэл, чирэгдлийг арилгах, давхардлыг бууруулах, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг төрийн захиргааны төв байгууллага болон харьяа агентлагийн Салбарын хяналтын газрын холбогдох албан тушаалтнуудын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд салбарын хяналт шалгалт давхардаж байгаагаас шалтгаалж аж ахуйн нэгжүүдэд учирч буй хүндрэл, чирэгдлийг арилгах, давхардлыг бууруулах асуудлыг судлан, холбогдох судалгаа, мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийсэн.

Салбарын хяналтын чиг үүргийн шинжилгээг хийхдээ дараах ажлуудыг гүйцэтгэж, үр дүнг нэгтгэсэн. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцооны өөрчлөлт, салбарын хяналтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, зурагласан;
- Салбарын хяналтыг зохицуулж буй нийт 114 хууль тогтоомжийн хүрээнд тусгагдсан чиг үүргүүд нь хяналт шалгалтыг хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны төв болон бусад байгууллагад хэрхэн хуваарилагдсан талаар судалгаа гаргаж, хууль тогтоомжийн хувьд давхардал байгаа эсэхийг тодорхойлсон.
- Хяналт шалгалтыг гүйцэтгэхэд ашиглаж байгаа батлагдсан хяналтын хуудаст тусгасан хууль, дүрэм, журам, стандартын заалтуудыг хууль тогтоомжоор олгосон чиг үүрэгтэй харьцуулах байдлаар чиг үүргийн давхардлын судалгаа гаргасан.

Салбарын хяналт шалгалт давхардаж байгаагаас шалтгаалж аж ахуйн нэгжүүдэд учирч буй хүндрэл, чирэгдлийг арилгах, давхардлыг бууруулах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулсан болно.